**2022 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**
(Аймгийн Засаг даргын Тамгын газар)

2023 оны 01 дүгээр сарын 27

| Бүтэц | № | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Төлөвлөсөн онд хүрэх түвшин 2022 | Хариуцах байгууллага | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 1.* Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал** | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1.* Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Төв суурин газрын орчны бохирдлын түвшинг бууруулна. | - | Агаарын чанарын индексийн түвшин Индекс | 0 | 100> | Аймгийн төвд жижиг оврын тоосонцрын багажтай болсноор 2022 оны 1 дүгээр сараас эхлэн агаарын жижиг ширхэгт тоосонцрыг /PM2.5/ тогтмол хэмжиж эхэлсэн бөгөөд агаарын чанарыг 3 төрлийн үзүүлэлтээр үнэлэхэд агаарын чанарын индекс 0-50 /100>/ буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, агаар цэвэр ангилалд багтаж байна. | 75 |
| | | | - | Бохирдсон хөрсний талбайн хэмжээ /бууралт/ га | 205 | 123 | Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тохижилтын ажил Хулд суманд 0.2 га, Дэлгэрцогт суманд 0.2 га, Эрдэнэдалай суманд 7 га, Адаацаг суманд 1.5 га, Сайнцагаан суманд 4 га талбайд шууж, булшлах ажил хийгдэж бохирдсон хөрсний талбайн хэмжээ 12.9 га-р буурч 129.8 байснаас 116.9-д хүрч буурсан үзүүлэлттэй байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Утаа бага ялгаруулах төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх | УТ 608.5 | 15 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо | 2 | 3 | БОАЖЯамнаас санхүүжүүлэн “Регал инженеринг” ХХК-тай гэрээ байгуулсны дагуу “Дундговь –Ус” ОНӨҮГ-ын 2 дугаар зууханд 3, “Тэвшийнговь” ХХК-ийн зууханд 1, “Ган-Илч” ХХК-ийн зууханд 4, нийт төвлөрсөн халаалтын 15 квт-аас дээш хүчин чадалтай 8 зуухны янданд утаа шүүгч суурьшуулах ажил хийгдсэн. Улсын төсвийн 608.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. | 100 |
| | 2 | Нам даралтын зуухны тоог бууруулах | - | Нам даралтын зуухны бууралтын тоо | 80 | 70 | “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого”-ийг БОАЖГазар, УЦУОШТөв хамтран зохион байгуулсан. Тооллогын дүнгээр Хулд суманд 4 Байгууллага, Эрдэнэдалай суманд 1 ААНэгж төвлөрсөн халаалтын зууханд холбогдож 15-100 кВт-ын нам даралтын зуухны тоо 69 болж буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| | 3 | Гэр хорооллын бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонг нэмэгдүүлэх | | Гэр хорооллын сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь | 28 | 34 | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх болзолт уралдааныг 3 сарын хугацаанд зохион байгуулж 13 айлын материал ирж эхний 5 байрыг шалгаруулла. Аяны хүрээнд 4670 нүхэн жорлонд ариутгал хийж, 19 удаагийн сургалтад 943 иргэн хамруулсан. Дэлгэрцогт суманд 1, Дэрэн суманд 4 өрх сайжруулсан ариун цэврийн байгууламж, Гурвансайхан сумд 2 өрх шинээр шаардлага хангасан | 83,3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бохирын шугамд холбогдлоо. Гэр хороололд нийт 7 өрх ариун цэврийн байгууламжаа байгальд ээлтэй байдлаар шийдэж аймгийн хэмжээний эко жорлонгийн тоог 42 болгож, нийт сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх 33 хувийг эзэлж байна. | |
| | 4 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | ОНТ 0.8 | Цэвэрлэсэн талбайн хэмжээ /Га/ | 325 | 250 | Нийтийн эдэлбэр талбайн бүх нийтийн их цэвэрлэгээг 15 суманд 23 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 87 аж ахуйн нэгж, байгууллагын 3282 ажилчид, албан хаагчид, иргэдийг хамруулан нийт 261.3 га талбайгаас 422.5 тн энгийн хог хаягдлыг орон нутгийн төсвийн 0.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулан цэвэрлэж хог хаягдлын нэгдсэн цэгт төвлөрүүлсэн. | 100 |
| | 5 | Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах | ОНТ 75.2 Хувийн хэвшил 48.0 | Тухай жилд шууж булшилсан талбайн хэмжээ Га | 35 | 21 | Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тохижилтын ажил Хулд суманд 0.2 га, Дэлгэрцогт суманд 0.2 га, Эрдэнэдалай суманд 7 га, Гурвансайхан суманд 15 га, нийт 4 сумын 22.4 га газарт шууж, булшлах ажил хийгдсэн. Орон нутгийн төсвийн 75.2 сая, хувийн хэвшлийн 48.0 сая төгрөгийг зарцуулав. | 100 |
| | 6 | Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх | ОНТ 13.4 Хувийн хэвшил 14.0 | Нэмэгдүүлсэн хогийн савны тоо | 25 | 230 | Сайнцагаан, Говь-угтаал, Сайхан-овоо, Баянжаргалан, Цагаандэлгэр, Дэрэн, Өлзийт, Луус, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өндөршил, Эрдэнэдалай сумдад | 97.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуванцар цуглуулах болон 3 төрлөөр ангилан ялгах, эмнэлгийн хог хаягдал ялгах зориулалт бүхий хогийн сав нийт 94 аж ахуйн нэгж, байгууллага шинээр байршуулж, аймгийн хэмжээний нийт ангилан ялгах хогийн сав 224 болж нэмэгдэв. Орон нутгийн төсвийн 13.4 сая төгрөг, Хувийн хэвшлийн 14.0 сая төгрөг, нийт 17.4 сая төгрөг зарцуулав. | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:2.* Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 28 хувь байсныг 2024 онд 44 хувьд хүргэнэ. | ОНТ 20.0 БХНСАХЗ 19.7 | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь | 28 | 36 | Дэлгэрхангай суманд 2 цэвэршүүлэх төхөөрөмж шинээр суурилуулснаар аймгийн хэмжээнд хүн амын 36 хувь нь шаардлага хангасан цэвэршүүлсэн ундны усны эх үүсвэрээр хангагдсан. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах | ОНТ 20.0 | Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо | - | 2 | Дэлгэрхангай суманд орон нутгийн хөгжлийн сангийн 20 сая төгрөгийн хөрөнгөөр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг сумын төвийн ундны усны 2 эх үүсвэр дээр суурилуулав. Орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулав. | 100 |
| | 2 | Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | БХНСАХЗ 4.7 | Тэмдэгжүүлсэн булгийн тоо | - | 50 | Тус аймгийн хэмжээнд усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор 160 булаг, нуур тойромд 40909,29 га усны сан бүхий газар нутгийг аймгийн ИТХурлын 2022 оны 04 дүгээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дэлгэрхангай, Баянжаргалан, Сайнцагаан, сумдын нутагт усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд 37, нийт 59 булгийн эх дээр тэмдэг, тэмдэглэгээг байршуулав. БХНСАХЗардлаас 4.7 сая төгрөг зарцуулав. | |
| | 3 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | БХНСАХЗ 15.0 | Хашсан булгийн тоо | 53 | 59 | Луус сумын “Зодохын булаг”, Хулд сумын “Жирмийн булаг”, Сайхан-Овоо сумын “Жарантайн булаг”-ийн эхийг хашин хамгаалах гэрээг тус сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, газрын даргын А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг актаар хүлээн авлаа. Тус булгуудыг хашиж хамгаалснаар урсац нэмэгдэж 16 өрхийн бог, бод нийлсэн 10655 мал ундаалах боломжийг бүрдүүллээ. Нийт 59 булгийн эхийг хашиж хамгаалав. БХНСАХЗардлаас 15.0 сая төгрөг зарцуулав. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:3* Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 569.4 га-д хүргэж, ургалтын хувийг нэмэгдүүлнэ. | УТ 90.0 ОНТ 122.0 Хувийн хэвшил 116.3 | Ногоон байгууламжийн хэмжээ га | 369.4 | 469.4 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 122884 мод, сөөг тарьж ургууллаа. “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд 8 га, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 5 га, “Эрдэнэс силвер ресурс” ХХК эзэмшлийн газар дээрээ 37.5 га нийт 50.5 га газарт ойн зурвас байгуулж нийт ногоон байгууламжийн хэмжээ 469.9 га болсон. | 100 |
| | | | | Ургалтын хувь | 75 | 77 | Ургалт 77%-тай байна. | |
| Арга хэмжээ | 1 | Тухайн жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах | - | Батлуулсан сумын тоо | 15 | 15 | Аймгийн хэмжээнд ойн зурвас байгуулахаар 750.91 га, мод үржүүлгийн газар байгуулах зориулалтаар 104.33 га, 15 суманд нийт 855.24 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан. | 100 |
| | 2 | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | УТ 90.0 БХНСАХЗ 12.5 | Тухайн жилд нэмэгдсэн ногоон байгууламжийн хэмжээ /га/ | 5 | 5 | Сум дундын ойн ангиас Өлзийт суманд 2, Дэлгэрхангай суманд 2, Говь-Угтаал суманд 1, нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг тус сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, аймгийн Засаг даргын А/382 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Эрдэнэдалай суманд 8 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг “Тэнгэрлэг ой” ХХК гүйцэтгэж аймгийн ЗДТГазрын даргын А/240 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. | |
| | 3 | Иргэн, ААНБайгууллагыг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод сөөг тарих ажлыг зохион байгуулах | УТ 90.0 ОНТ 122.0 Хувийн хэвшил 116.3 | Жилд тарьсан модны тоо | 13845 | 27000 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2 удаа зохион байгуулж, 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэнийг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Нийт 122884 мод, сөөг тарьж ургуулж байна. Улсын төсвөөр 90.0, орон нутгийн төсвөөр 122.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг зарцуулав. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:4 Газрын доройтлыг бууруулах, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувь болгоно. | | Нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь | 8.3 | 16.5 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 16.6 хувийг эзэлж байна. | 100 |
| | 1 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 80 га-р нэмэгдүүлэх | Хувийн хэвшил 110.4 | Техникийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га | 79.6 | 119.6 | Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | | | | | | | байна. Нийт 6 сумын нутаг дэвсгэрт 9 талбар бүхий газарт 7.77 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. Үүнд: Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газарт 5.31 га, хайгуулын улмаас эвдэрсэн талбайд 0.12 га, эзэнгүй эвдэрсэн газарт 2.3 талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийгдэж нийт нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 121.02 га-д хүрсэн. | 100 |
| | 2 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-р нэмэгдүүлэх | Хувийн хэвшил 12.0 | Биологийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га | 1 | 11 | Тус аймгийн 4 сумын нутаг дэвсгэрт 5 аж ахуйн нэгж 4.2 га талбайд мод бут, олон наст ургамал тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, мөн эзэнгүй эвдэрсэн газрын тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад Дэлгэрцогт сумын 14.54 га газар байгалийн аясаар ургамалжин нөхөн сэргээгдсэн үзүүлэлт гарсан. Нийт биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай 24.74 га-д хүрсэн. | 100 |
| | 3 | Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх | ХХ 51.6 | үр өгөөжийг нэмэгдүүлсэн төслийн тоо | 5 | 15 | 2022 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах 12 ААНэгжийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгуулсан. Үүнээс 7 ААНэгж 22600 мод, 2 ААНэгж 11 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 1 аж ахуйн нэгж уст | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цэгийн тохижилт, цөөрмийн ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Ингэснээр уул уурхайн 17 төсөлд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгуулсан.Хувийн хэвшлийн 51.6 сая төгрөг зарцуулав | |
| | 4 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах | - | Нэгдсэн хяналт шалгалтын тоо | 1 | 2 | 7 удаагийн хяналт шалгалтаар давхардсан тоогоор уул уурхайн 19-н аж ахуй нэгжид Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын газар, сумын ЗДТГазрын хамтарсан хяналт, шалгалт хийн зөрчлийг илрүүлж үйл ажиллагааг зогсоосон. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 5*** **Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ. | | Нийт газар нутагт эзлэх хувь | 27 | 32.5 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор “Сүм хөх бүрд” аймгийн тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж 32588.17 га талбайг улсын тусгай хамгаалалтад оруулах саналыг аймгийн Засаг даргын албан бичгээр БОАЖЯаманд хүргүүлэв. Ингэснээр улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн хэмжээ 32.9 хувь болж нэмэгдэв. | |
| Арга хэмжээ | 1 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | БХНСАХЗ 6.8 | Улсын тусгай хамгаалалттай нутгийн хувь | 5.7 | 10.2 | “Сүм хөх бүрд” аймгийн тусгай хамгаалалттай 548.5 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 32588.17 га болгон улсын тусгай хамгаалалтад оруулахаар Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 37 дугаар тогтоол тус тус гаргуулж, албан бичгээр БОАЖЯаманд хүргүүлж. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 5.7 хувиас 10.6 хувь болсон. | 100 |
| | 2 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | - | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хувь | 21.3 | 22.3 | Хулд сумын Олдохын хийд, Дэрэн сумын Бумбатын овоо, Бумбатын шорвог, Тэгшийн суурин орчмын сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар батлав. Ингэснээр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 21.8 хувиас 22.5 хувь болж нэмэгдэв. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 6 Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Биологийн олон янз байдлын нөөцийг хамгаалах, арга хэмжээний тоог нэмэгдүүлэх | - | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | 13 | 23 | Идлэг шонхор шувууны үржлийг дэмжих зорилгоор Адаацаг сум 3 шонхрын үүр, 13 суултуур, Дэрэн сум 8 суултуур байгуулж, засаж янзалсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Шивүүрт цульхир" /Agriophyllum pungens (Vahl)Link/ ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Сум дундын ойн ангийн 0,1 га талбайд тарималжуулж, дуслын системээр байнгын усалгааг шийдэв.<br>6 агнуурын бүсэд 37 удаагийн давтамжтайгаар 511 боодол өвс, 12 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан.<br>Нийт 51 арга хэмжээг авч хэрэгжүүлэв. | |
| Арга хэмжээ | 1 | Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, идэш тэжээлийн хомсдолоос үүссэн зүй бус хорогдлоос сэргийлж, биотехникийн арга хэмжээ авах. | ОНТ 20.0 Хувийн хэвшил 5.0 | Биотехникийн арга хэмжээний тоо | 10 | 22 | Тус аймгийн 8 сум, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 4 газар, 6 агнуурын бүсэд 511 боодол өвс, 12 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэргийг хянах боломжтой болж Сайхан-Овоо сумын агнуурын бүс гандуу, хуурайшилтай байсан тул зэрлэг амьтдын хорогдлоос сэргийлж шинээр 1 уст цэг, Өлзийт сумын Хөтлийн усанд шинээр 1 уст цэг нийт 2 уст цэг байгуулж нийт 24 био техникийн арга хэмжээг зохион байгууллаа. Орон нутгийн төсөв 20.0 сая.төг, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хувийн хэвшлийн 5.0 сая.төг, нийт 25 сая төгрөгийг зарцуулсан. | |
| | 4 | Байгалийн ашигт ургамлыг хамгаалж, тарималжуулах. | БХНСАХЗ 2.9 | Тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 1 | Ховор ургамлын жагсаалтад орсон "Шивүүрт цульхир" /Agriophyllum pungens (Vahl)Link/ ургамлын үрийн жишиг плантаци байгуулах зорилгоор Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын 0,1 га талбайд үрээр тарималжуулж, дуслын системээр байнгын усалгааг шийдсэн. БХНСАХЗардлаас 2.9 сая төгрөгийг зарцуулав. | 100 |
| **Үндсэн чиг үүргийн нэр: 7 Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гадаад, дотоод жуулчдын тоог 40000-д хүргэнэ. | - | Тухайн жилийн жуулчдын тоо | 19.5 | 23.0 | Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаадын 9657 жуулчин, дотоодын 30257 жуулчин ирсэн байна. Нийт 39914 аялагч, жуулчид ирсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Аялал жуулчлалын гол бүс нутгийг түшиглэсэн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжиж, хүчин чадлыг нэмэгдүүлэх | УТХО 70.0 Хувийн хэвшил 200.0 | Жуулчин хүлээн авах хүчин чадал Ор хоног | 1004 | 1100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ижий говь” төсөл, хөтөлбөрөөр 2 цомцог гэр 8 ор хоног, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газар “Говь хулан” жуулчны бааз 10 гэр 40 ор хоног, Бага газрын чулуунд Чандмань гэр буудал 12 гэр 48 ор хоног нэмэгдэж аймгийн хэмжээнд нийт ор хоногийн тоо 1140 боллоо. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улсын төсвийн 70.0 сая төгрөг, хувийн хэвшлийн 200.0 сая төгрөг зарцуулав. | |
| | 2 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх | - | Стандартын хэрэгжилтийн үнэлгээний хувь | 80 | 85 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 76 дугаар тоотоор аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгжид үйлчилгээний стандарт, тохирлын гэрчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулсан. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуй нэгжид тохирлын үнэлгээ хийсэн бөгөөд стандартын хэрэгжилтийн үнэлгээний дундаж 90 хувьтай байна. | 100 |
| | 3 | Жуулчдын голлон зорих газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах | УТХО 197.2 | Байгуулагдсан отоглох цэгийн тоо | 1 | 3 | Тус аймгийн Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт “Отоглох цэг” байгуулсан. Отоглох цэгт 1,2 га талбайн хамгаалалтын хашаа, Машины зогсоол 40, Майхан барих талбай 31, Ариун цэврийн байгууламж 24 мкв байр, септик танктай, Шингээлтийн талбай 36 мкв, ОО 5, Угаалтуур 2, Ус нөөцлөх сав 2, Явган зам 120 м, Гэрэлтүүлэг 8, Сүүдрэвч 2, Ширээ, сандал 4, Гал түлэх цэг 2, Шорлогийн зуух 2, Угтах хаалга, Мэдээллийн самбар 2, Тэмдэг, тэмдэглэгээ 13, Тэмээн зэл 1 ширхгийг хийсэн. Газрын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны Дугаар 21/2022 үүрэг даалгаврын биелэлт, актаар хүлээж авсан. Аймгийн хэмжээнд нийт 3 газарт “Отоглох цэг” байгуулагдсан.<br>Улсын төсвийн 197.2 сая төгрөг зарцуулав. | |
| | 4 | Олон улсын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчлах | БХНСАХЗ 2.4 Хувийн хэвшил 2.6 | Тухайн жилд жуулчин хүлээн авахаар байгуулсан гэрээний тоо | 100 | 200 | “ITM 2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО- 2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнд Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Говийн шуранхай АЖХолбоо, 10 аж ахуйн нэгж, байгууллага, 3 иргэн нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай 2023 онд жуулчин хүлээн авах 257 гэрээ байгуулж, 2600 тараах материал тарааж ажиллалаа.<br>Нийт 2 үзэсгэлэнд 10 аж ахуйн нэгж, байгууллага, 3 иргэн оролцож 257 гэрээ байгуулав.<br>БХНСАХЗардлаас 2.4 сая төгрөг болон хувийн хэвшлээс 2.6 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| | 5 | Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх | ОНТ 20.0 | Цахим үйлчилгээнд хамрагдсан ААНэгжийн тоо | - | 8 | Айхотел ХХК-тай гэрээ байгуулж “Dundgovi” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформыг хийлгэсэн. Энэхүү платформд жуулчны бааз, зочид буудал, дэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буудал, гэр буудал, худалдаа үйлчилгээний нийт 56 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.<br>Орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийг зарцуулав. | |
| | 6 | Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн уламжлалт, өв соёлын эвент арга хэмжээ зохион байгуулах | ОНТ 28.0 БХНСАХЗ 1.0 | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Говь каравансерай” жуулчны баазтай хамтран 6 сард зохион байгуулсан “Сэтгэшгүй оддын чуулган” эвент арга хэмжээнд 220 аялагч, Адаацаг сумын “Сүм хөх бүрд” байгалийн дурсгалт газарт 9 сард зохион байгуулсан “Адууны өв соёлын баяр” эвент арга хэмжээнд 15 сумын 42 адуучин оролцож, гадаад, дотоодын 1200 аялагч, нийт 2 эвент арга хэмжээнд 1420 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.<br>Орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөг, БХНСАХЗардлаас 1.0 сая төгрөг зарцуулав. | 100 |
| | 7 | Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчин хүлээн авах малчин өрхийн нэгдсэн сүлжээг бий болгож дэмжлэг үзүүлэх | ОНТ 33.0 | Хамрагдсан малчин өрхийн тоо | - | 20 | “Дундговьд төвлөрцгөөе” аялал жуулчлалын анхдугаар форумыг 03 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг сайжруулж, чадавхыг нэмэгдүүлэх илтгэл мэдээлэл, сургалтад 175 салбарын ажилтныг, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг GIZ (space) төсөлтэй хамтран Нутгийн иргэдэд аялал жуулчлал | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрхлэхэд мэдлэг олгох “Манай нутгаар зочлоорой” гарын авлага номын танилцуулга сургалтад 31 иргэн, нийт 2 удаагийн чадавхжуулах сургалтад 40 малчин өрх хамрагдсан. Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс 33.0 сая төгрөг зарцуулав. | |
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 2.*** **Газрын харилцаа, барилга, хот байгуулалт** | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:1.*** **Барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | 2024 он гэхэд 15 сумыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгоно. | - | Батлуулсан ажлын зургийн даалгаврын тоо | 5 | 13 | 8 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 100 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд Луус, Хулд, Эрдэнэдалай, Өндөршил, Дэрэн, Дэлгэрхангай сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний санхүүжилтийг 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр 435.3 сая төгрөг баталсан. Дэлгэрхангай, Өндөршил, Хулд, Луус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авсан. Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 80 хувьтай, Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 70 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Нийт 14 сумын зургийн даалгаврыг батлуулан ажиллалаа. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулж, батлуулах | | Хүлээн авсан ажлын зураг, төсвийн тоо | 4 | 11 | Эрдэнэдалай, Өндөршил, Дэрэн, Дэлгэрхангай, Баянжаргалан, луус, Хулд сумдын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Ингэснээр нийт 14 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумын зургийн даалгаврыг батлуулан ажиллалаа. | |
| | 2 | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | | Ажлын гүйцэтгэлийн хувь | 5 | 4 | 2022 онд Луус, Хулд, Эрдэнэдалай, Өндөршил, Дэрэн, Дэлгэрхангай сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний санхүүжилтийг 2022 оны ОНХС-ийн хөрөнгөөр 435.3 сая төгрөг баталж хүлээн авсан. | 100 |
| Зорилт | 2 | Ус хангамж, ариутгах татуурга, барилга байгууламжийг 6 суманд бий болгох | 1,800 ГХ | Батлуулсан ажлын зургийн даалгаврын тоо | 3 | 6 | Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилттэй Эрдэнэдалай сумын төвийн 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний “Сайн констракшн” гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>Сайхан-Овоо сумын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн дуусгалын ажлыг “Алтайн үндэс констракшн” ХХК гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>“Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус сумын төвд хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгч “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж ажлын явц 25 хувьтай, он дамжин хэрэгжинэ. | 100 |
| Арга хэмжээ | 1 | 6 сумын усан хангамж, ариутгах татуурга, барилга, | 0 | Батлуулсан ажлын зургийн даалгаврын тоо | 3 | 6 | 2022 онд Говь-Угтаал, Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам | 83.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууламжийн ажлын зургийн даалгавар батлуулах | | | | | сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлын зургийн даалгаврыг боловсруулж, батлуулсан. | |
| | | | 0 | Хүлээн авсан ажлын зураг, төсвийн тоо | 10 | 14 | Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг "Сонголт дизайн" ХХК боловсруулж, магадлалаар батлуулан БХБЯаманд хүлээлгэн өгсөн. Говь-Угтаал сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг "Их мянган инженерчлэл" ХХК боловсруулж байгаа бөгөөд ажлын явц 85 хувьтай байна. | |
| | 2 | "Аймгийн төвийн шинээр баригдах хоногт 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, гэр хорооллын 5,57км гадна бохир усны шугам сүлжээ"-ний ажлыг ашиглалтад оруулах | 500.0 ГХ | Ажлын гүйцэтгэлийн хувь | 40 | 100 | Аймгийн төвийн хоногт 3000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламж, гэр хорооллын 5,57км бохир усны шугамын ажлыг "Сайн констракшн" ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ашиглалтад оруулсан бөгөөд тус цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг "Дундговь-Ус" ОНӨҮГ хариуцан ажиллаж байгаа бөгөөд туршилт, тохируулгын ажил хийгдэж хэвийн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Газрын маргааны асуудал 71 байсныг 2024 онд 35 болгон бууруулна. | 0 | Шийдвэрлэсэн газрын маргааны бууралтын тоо | 71 | 54 | 2022 онд газрын 25 маргааныг шийдвэрлэж газрын маргааныг 46 болж бууруулав. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлэх | 0 | Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө хаваржааны тоо | 0 | 7 | 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 19 нэгж талбарыг төлөвлөн 9 нэгж талбарт харьяа сумын Засаг даргын Захирамж гаргуулан шийдвэрлэж Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд хилийн цэсийн гадна олгогдсон 99 нэгж талбарыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр саналыг хүргүүлсэн. | 100 |
| | 2 | Аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах | 0 | Тухайн жилд шийдвэрлэсэн маргааны тоо | 0 | 3 | Аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны 25 газрын маргааныг шийдвэрлэж 12 иргэний өвөлжөө, хаваржааны газрыг 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн. | 100 |
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 3.* Аймгийн эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, хяналтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримтлан аймгийг гадаадад төлөөлөн, гадаад ажил арга хэмжээг оновчтой төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулна.*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөрөнгө оруулалт 500 сая төгрөг байсныг 2024 он гэхэд 20 дахин нэмэгдүүлнэ. | | Хөрөнгө оруулалтын хэмжээ Сая.төг | 500.0 | 5,000.0 | 2022 онд БНХАУ,Солонгос,Япон Улсын муж хотууд,Канад, АНУ-ын санхүүжилттэй олон улсын болон төрийн бус байгууллагууд, Монгол Улс дахь Элчин сайдын яамдтай хамтран 15 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн орон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт 1,972,945,563 төгрөг байна. | |
| Арга хэмжээ | 1 | Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, олон улсын төслийн байгууллагын тоог нэмэгдүүлэх | | Нэмэгдүүлсэн улс, орнуудын муж, хотын тоо | 2 | 4 | Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяан хот, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Баяннуур аймагтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан. | 100 |
| | | | | Шинээр нэмэгдсэн олон улсын төслийн байгууллагын тоо | 7 | 9 | Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”, Жайка олон улсын байгууллагын “Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” хоёр төсөл шинээр нэмэгдэн орон нутгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалттай 13 төсөл хөтөлбөр хэрэгжсэн. | |
| | 2 | БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах | | Тухайн жилд зохион байгуулах арга хэмжээний тоо | 0 | 2 | БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд Гуяаны төглийн 4, 5 дугаар талбайд 10,000 дуслын усалгааны системийг нэмэгдүүлсэн.<br>Мөн Гуяан хотын төлөөлөгчдийг хүлээн авч хамтын ажиллагааны гэрээг өргөжүүлэн шинэчлэн байгуулсан зэрэг 2 арга хэмжээг зохион байгуулав. | 100 |
| | 3 | Төрийн албан хаагчдыг Гадаадад сургах, туршлага судлах арга хэмжээнд хамруулах | | Тухайн жилд хамрагдсан албан хаагчдын тоо | 21 | 20 | БНСУ, Япон Улсад 2 албан тушаалтан туршлага судлах арга хэмжээнд оролцон, Зүүн хойд Азийн Нутгийн Захиргаадын холбоонд 1ажилтан томилогдон ажиллаж байна. Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын холбооноос зохион байгуулсан цахим | 25 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад хоёр албан хаагч хамрагдан нийт 5 албан хаагч туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3.-т заасны дагуу туршлага судлах арга хэмжээнд албан хаагчдыг биечлэн оролцуулах боломжгүй байна. | |
| **Үндсэн чиг үүргийн нэр: 2. Аймгийн хэмжээний нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны хууль, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах, дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ. | | Тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа ТАХ-ийн дундаж хувь | 62 | 64 | Аймгийн хэмжээний 3270 төрийн албан хаагчийн 63 хувь нь 3-аас дээш жил ажилласан төрийн албан хаагч ажиллаж байна. | 75 |
| | | | | Дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь | 64.9 | 74 | Орон нутгийн эрүүл мэнд, Боловсрол, Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай АШУИС, МУБИС, ХАИС, Этүгэн, Глобал удирдагч их сургуулиудад сарайлцаж 35 оюутнуудтай орон нутагт гэрээ байгуулан орон нутагт дутагдалтай боловсон хүчний хангалт хийснээр дутагдалтай байгаа боловсон хүчний хангалт 5 % иар өсч 74 % хүрсэн байна. | |
| | 1 | Орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг бэлтгэх | | Гэрээ байгуулсан оюутны тоо | 10 | 35 | Боловсролын салбарын Сургуулийн өмнөх багш, ЕБС-ийн багш, Эрүүл мэндийн салбарын Их эмч, сувилахуй, Хөдөө аж ахуй, Мал эмнэлгийн малын их эмч, Инженер, Эрх зүй, Соёл урлаг, ОХУ-ын Эрхүү мужийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | | | | | | | А.А.Ежевскогын нэрэмжит Хөдөө аж ахуйн их сургуулийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт мэргэжлээр суралцаж буй 35 оюутантай гэрээ байгуулан орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчнийг бэлтгээд байна. | |
| | 2 | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж дэмжлэг үзүүлэх | ОНТ 195,6 | Дэмжлэг авсан төрийн албан хаагчийн тоо | 0 | 100 | Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 19 төрийн албан хаагчид 132,0 сая төгрөгийн гэр, байр орон сууцны дэмжлэг, 6 албан хаагчид эрүүл мэндийн дэмжлэг 35.0 сая төгрөг, дэмжлэгийг тус тус олгосон байна. Эрдэнэдалай суманд тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй 7 төрийн албан хаагчид тус бүр 1.0 сая төгрөг, 7 сумын ЗДТГ-т нэн шаардлагатай 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 78 төрийн алан хаагчид сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулж нийт 124 төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж 232.0 сая төгрөгийг зарцууллаа. | 100 |
| | 3 | Төрийн албан хаагчдыг тогтмол сургалтад хамруулах | | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1600 | 1800 | 2022 онд Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 13, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 20, төрийн албанд анх томилогдсон иргэнийг мэргэшүүлэх сургалтад 10, “Алсын хараа-2050” зайн сургалтад 8, сс“Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харилцааны зохицуулалт, шинэчлэлт” зайн сургалтад 10, “Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг” зайн сургалтад 9 хүн Аймгийн ЗДТГ-ын дарга нарт зориулсан “Нутгийн захиргааны байгууллагын удирдлага зохицуулалт” сэдэвт богино хугацааны зайн сургалтад 11, үр дүнд суурилсан удирдлага сэдэвт богино сургалтад 4 албан хаагч нийт 85 хүнийг богино болон дунд хугацааны сургалтад хамрууллаа. Ингэснээр аймгийн хэмжээнд нийт 131 төрийн албан хаагч богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. Глобал удирдагч их сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулан 160 төрийн албан хаагчийг магистрын сургалтад хамруулж сургалтад 37.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Төрийн албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр салбар салбарын хэмжээнд зохион байгуулсан улс бүсийн хэмжээнд зохион байгуулсан сургалтуудад 256 төрлийн сургалтад 2156 төрийн албан хаагч хамрагдсан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 2447 төрийн албан хаагч сургалтад хамрагдсан байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Үндсэн чиг үүрэг: 3 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Ил тод байдлын аймгийн үнэлгээний үзүүлэлтийг 2019 онд 75 хувьтай байгааг 2024 онд 87 хувьд хүргэнэ. | | Ил тод байдлын үзүүлэлт хувь | 75 | 81 | Байгууллагын ил тод байдлын 46 шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэн ажиллаж 2022 оны жилийн эцсийн байдлаар 82,5 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа. | 100 |
| | 1 | Агентлагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах | | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | 2 | 7 | АЗДТГ-аас зөвлөн туслах ажлын хэсэг Төрийн байгууллагуудын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид ажил эрчимжүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Мөн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Соёл урлагийн газар, Статистикийн хэлтэс, ГБХЗХГ, НДХ, Татварын хэлтэс, УЦУОШТ, ЭМГ зэрэг 8 байгууллагын ил тод байдлын асуудал хариуцсан албан тушаалтанд биечлэн зөвлөгөө өгч, мэдээлэл хэрхэн байршуулах, шинээр хэрэгжиж буй ЗД-Г-ын тогтоолыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах арга зүйгээр хангаснаас гадна бүх байгууллагуудын ил тод байдлын үнэлгээг хагас, бүтэн жилээр цахимаар 2 удаа хийж, ажил эрчимжүүлэх, цахимд мэдээлэл байршуулах зөвлөмж өгсөн. | 100 |
| | 2 | Сумдын ЗДТГ-ын болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод | | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | 2 | 3 | Аймгийн нэгдсэн сайтад 15 сумын ил тод байдлын цэсэд шалгуур үзүүлэлт бүрээр мэдээллээ байршуулах цэсийг үүсгэн бүх сумдын ил тод байдлын асуудал | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдалд хяналт тавих, зөвлөн туслах | | | | | хариуцсан албан тушаалтнуудад мэдээллээ хэрхэн оруулах талаар видео бэлтгэн хүргүүлснээс гадна сумдын мэдээллийн ил тод байдлыг хагас, бүтэн жилээр 2 удаа цахимаар хянан зөвлөмж өгсөн. Мөн АЗДТГ-аас баруун, зүүн сумдад ажиллахаар томилогдсон ажлын хэсэг бүх сумдын мэдээллийн ил тод байдалтай газар дээр нь танилцан зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | |
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 4* Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдал** | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1.* Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | | Хэрэгжилтийн хувь | 65 | 75 | Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг тодотгох, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг даалгаваржуулах, орон нутгийн цэргийг зохион байгуулах зэрэг 9 арга хэмжээ зохион байгуулан хэрэгжүүлэн “Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”, бусад нууцтай холбогдон гарсан эрх зүйн актын хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажиллаж байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагаа зохион байгуулах | | Хяналтын тооны биелэлтийн хувь | 90 | 94 | “Цэргийн тоо бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 05-26-ны өдрүүдэд зохион байгуулан Аймгийн 18-60 насны цэргийн үүрэгтэн 82,7 %-тай бүртгэлд хамрагдлаа. Зэвсэгт хүчний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Жанжин штабаас ирүүлсэн 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын хяналтын тоог 100 хувь, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын хяналтын тоог 92 хувьтай биелүүллээ.Хяналтын тооны биелэлт 97 хувьтай байна. | |
| | 2 | Бүх шатны Засаг дарга, Тамгын газрын дарга, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн цэрэг, хамгаалалтын нэгжийн цэргийн сургалт зохион байгуулах | | Хамрагдалтын хувь | 81 | 83 | “Цэргийн бэлтгэл” сургалтыг Говьсүмбэр аймгийн Чойр хотод 2022 оны 9 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд аймгийн 15 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар, Цэргийн штабын 3 офицер нийт 18-н алба хаагч оролцож Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 23-наас 06 дугаар сарын 03-ныг дуустал 33 хүний бүрэлдэхүүнтэйгээр явагдаж 100 хувь хамрууллаа | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 2*** **. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ. | | Гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын хувь | 60 | 68 | Албаны гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах зорилгоор гал түймэр унтраах тактикийн сургуулийг 1 удаа, тархалтын сургуулийг 24 удаа зохион байгуулж алба хаагчдын гамшгийн үед ажиллах чадавхыг нэмэгдүүлж, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан бол бүрэлдэхүүн, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах зорилгоор “Яаралтай цуглар” дохиогоор 8 удаа ажиллуулан хээрийн бэлтгэл, тусгай техник тоног | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг хийж, хүн нэг бүрийн хариуцсан багаж хэрэгслийг шалган нөхөн хангалтыг хийж бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан. Албан хаагчдын хээрийн үүргэвчний бүрдлийг 12 удаа шалгаж, гамшиг ослын дуудлагын үед ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн гамшигтай тэмцэх хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Хулд суманд Эрэн хайх аврах бүлгийг байгуулж хүн, хүч, техник хэрэгслээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд албаны гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 69.5 хувьтай хангагдаад байна. | |
| Арга хэмжээ | 1 | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах | | Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | 12 | 20 | Ард иргэдэд аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдлэгийг хүргэх зорилгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн байдлаар нийт 480 удаа зохион байгуулж 9200 иргэнийг буюу нийт хүн амын 19,5 хувийг хамруулаад байна. | 93,7 |
| | 2 | Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулах | ОНТ 10.0 | Эрэн хайх, аврах бүлгийг байгуулсан эсэх Тийм-1, үгүй-0 | 0 | 1 | Хулд суманд Эрэн хайх аврах бүлэг байгуулагдсантай холбоотойгоор орон нутгаас байрны асуудлыг шийдвэрлэж 10.0 сая төгрөгөөр бүлгийн байрны засварыг хийж үйл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж 2022 оны 10 дугаар сараас 07-ний өдрөөс Эрэн хайх, аврах бүлгийг томилон ажиллуулсан. Тус бүлэг нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гал түймрийн болон эрэн хайх, аврах ажиллагааны 3 удаагийн дуудлагаар гарч ажиллан 2 хүний амь нас, иргэдийн 98.3 сая төгрөгийг эд хөрөнгийг авран хамгаалсан. | |
| | 3 | Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах | - | Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо | 6 | 6 | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу нийт 15 сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2022 оны 05 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд, гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Луус, Гурвансайхан, Өндөршил сумдад 10 дугаар сарын 26-27-ний өдрүүдэд, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Хулд суманд 11 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулсан. | 100 |
| | 4 | Гамшигтай тэмцэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх | Төсөл 66.5<br>ОНТ 35.0 | Тоног төхөөрөмжийн хангалт Хувь | 65 | 71 | Хулд сумын Эрэн хайх аврах бүлэг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Бүгд Найрамдах Турк улсын Онцгой байдлын албанаас ирүүлсэн тусламжийн хөрөнгөнөөс тус аврах бүлэгт 11 ширхэг 66,536,000 төгрөгийн аврах ажиллагааны багажийг худалдан авсан. Мөн орон нутгийн гамшигтай тэмцэх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас шинээр байгуулагдсан Хулд сумын Эрэн хайх, аврах бүлэгт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 35.0 сая төгрөгийн 82 инчийн дэлгэц, иж бүрэн компьютер, принтер, гамшгийн үеийн харилцаа холбоог зохион байгуулах гар радио станц, энгэрийн камер зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжийг олгосон Ингэснээр техник, багаж хэрэгслийн хангалт 75 хувьтай хангагдаад байна. | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 3*** **Мэргэжлийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Бага дунд эрсдэлтэй иргэн аж ахуй байгууллагын тоо 2020 онд 2774 байсныг 2024 онд 2949 болгож нэмэгдүүлнэ. | | Тухайн жилд бага эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ын тоо | 1103 | 1135 | Шилэн хяналтын цахим системд 1165 объект бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. | 100 |
| | | | | Тухайн жилд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ын тоо | 1671 | 1724 | Шилэн хяналтын цахим системд 1754 объект дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна. | |
| Арга хэмжээ | 1 | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангуулж албан шаардлагын хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх | | Тухайн жилд ИААНБ-дад өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн дундаж хувь | 57.6 | 66 | Засаг даргаас өгсөн үүрэг 1, 14 иргэн, 8 ААНБ-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 22 өргөдөл гомдол хүсэлт ирсний дагуу 23 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 179 заалттай 16 албан шаардлага өгч шаардлагын биелэлт 78.8%- тай байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ыг төлөвлөгөөт шалгалтад хамруулах | | Тухайн жилд шалгалтад хамрагдах иргэн, аж ахуй нэгжийн тоо | 325 | 180 | Төлөвлөгөөт шалгалтад нийт 273 газар хамруулснаас 170 аж ахуй нэгж байгууллага, 103 иргэн хамруулсан байна. | 100 |
| | 3 | ИААНБ-дад салбарын сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | | Тухайн жилд сургалтад хамрагдсан иргэний тоо | 440 | 520 | 14 удаагийн сургалтад 53 төрлийн сэдвээр давхардсан тоогоор 711 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгуулсан. | 100 |
| | 4 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | | Тухайн жилд хийх урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо | 28 | 29 | 30 удаагийн урьдчилан сэргийлэх шалгалтаар 230 зөрчил илрүүлж, 193 буюу 84%-ийг шалгалтын явцад арилгуулсан. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 4* Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гэмт хэрэг 2019 онд 211 бүртгэгдсэн байсныг 2024 онд 190 болгон бууруулна. | - | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | 211 | 201 | Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 253 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 хэргээр буюу 10.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 0 |
| Арга хэмжээ | 1 | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэдэд үйлчлэх түр хамгаалах байртай болох | - | Түр хамгаалах байртай болсон эсэх /Тийм-1 Үгүй-0/ | 0 | 1 | Цагдаагийн газрын ашиглаж байсан хуучин барилгыг засварлаж, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах” байрыг байгуулахаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар зураг төсвийг гаргуулж, 2023 оны орон нутгийн төсөвт 250.0 сая төгрөгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулсан. Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчид холбон зуучилж хүчирхийлэлд өртсөн 45 иргэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үйлчилгээ, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. | |
| | 2 | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | | Зам тээврийн ослын бууралт | 30 | 28 | Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр “Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод” зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлсэн. Энэ төрлийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж олон нийтийн сүлжээнд байршуулсан. Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон гэрэл Цагаан шугам 2022” тэмцээнийг аймгийн Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран амжилттай зохион | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан.Гэмт хэрэг 2022 оны 12 сарын байдлаар 19 бүртгэгдсэн өнгөрсөн оноос 63.3 хувь буурсан байна. | |
| | 3 | Гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх | | Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт | 28 | 24 | Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 22 үйлдэгдсэн нь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1-ээр буюу 4.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 50 |
| | | | | Камержуулалт хийгдсэн сумын тоо | 3 | 8 | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд “Камер-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар тусгагдсаны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 8 суманд 45 камерыг шинээр суурилуулан ашиглаж байна. Аймгийн Онцгой комиссын санхүүжилтээр Сайнцагаан сумын төвийн хуучин теле камеруудыг засварлаж, төв зам дагуух 10 цэгт 21 ширхэг камерыг суурилуулан, хэвийн ажиллагааг хангаан ажиллаж байна. | |
| | 4 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | | Мал хулгайлах гэмт хэргийн бууралт Тоо | 29 | 26 | Энэ оны 12 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 11 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 21.4 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 36.4 хувьтай байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 5 сумдын малчдыг хамруулан малчдын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, Мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 1 удаагийн сургалт, 8 суманд зохион байгуулагдсан “Малчдын өдөр” өдөрлөгт 8 удаагийн яриа таниулга хийж нийт 3800 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан. | |
| Зорилт | 1 | Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг 2019 онд 71 байгааг 2024 онд 71,8-д хүргэнэ. | | Өмнөх жилээс нэмэгдүүлсэн хувь | 71 | 71,5 | 2021 онд Эрэгтэй хүний дундаж наслалт 71.54 эмэгтэй хүний дундаж наслалт 79.51 болж дундаж наслалтын зөрүү 7.97 байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгах | | Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай дотоод журамд тусгасан байгууллагын хувь | 20 | 60 | Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай дотоод журамд тусгасан байдлыг 51 байгууллагад үзэхэд 40 байгууллага тусгасан ба 81 хувийг эзэлж байна. | 100 |
| | 2 | Төрийн албан хаагч эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах | | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрэгтэй албан хаагчдын хувь | 30 | 50 | 51 байгууллагын 3423 албан хаагчийн 1092 нь буюу 32 хувь нь эрэгтэй албан хаагч байна. Үүний 941 нь буюу 86 хувь нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан. | 100 |
| | 3 | Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулах | | Хөвгүүд, эрэгтэйчүүдийг хамруулсан үйл ажиллагааны тоо | 1 | 2 | Эрэгтэйчүүдийн дунд 2 удаагийн чуулган, хэлэлцүүлэг зохион байгуулж, 450 иргэн хамрагдан, 5,4 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| | | | | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эрэгтэй оюутны тоо | 90 | 100 | Нийт оюутны тоо 277 ба эрэгтэй 91 оюутан 100 хувь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан. | |
| | | | | | | | | |
| Зорилт | 1 | Аймгийн ДНБ-д соёл урлагийн салбарын эзлэх хувь 2019 онд 0.61 хувь байсныг 2024 онд 0.77 хувьд хүргэнэ. | | ДНБ-нд эзлэх өсөлтийн хувь | 0.61 | 0.69 | Аймгийн ДНБ-д соёл урлагийн салбарын эзлэх хувь 0.8 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Соёл, урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийг шинэчлэх | | Тухайн жилд шинээр баригдсан барилгын тоо | 0 | 2 | Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилга гүйцэтгэгч компани "Одда ХХК"-нд гэрээний дүн 1,237.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 988.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хаалга цонх суурилуулсан. Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой гадна талын өнгөлгөө хийгдээгүй, дотор засал дутуу. Барилга захиалагчийн товчооноос шалгалт ирж гэрээний хугацааг сунгах үүрэг даалгавар өгсөн. Гүйцэтгэл 90 хувь.<br>240 хүний суудалтай Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч “ Хэрмээдэй ” ХХК. Гэрээний дүн 1,228.3 сая төгрөг, тайлант хугацаанд өссөн дүнгээр 750.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Барилгын гадна өрлөг, дээвэр, цонх суулгах ажил дууссан. Дотор заслын ажил эхлэсэн. Ажлын гүйцэтгэл 75 хувьтай түр зогссон.<br>Баянжаргалан сумын соёлын төв 2021-2022 онд ОНХСангийн хөрөнгөөр 101.018.028 сая төгрөгөөр гадна их засварын ажил хийгдсэн. | 0 |
| | 2 | Соёл, урлагийн салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах | | Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь | 60 | 64 | Соёл, урлагийн байгууллагууд өөрийн зардлаар сурч байгаа ажилтнуудад суралцах үед цалинтай чөлөө олгож, мөн мэргэшүүлэх сургалтуудад | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давтан хамруулж ажилласнаар салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 63,6-д хүрсэн нь өмнөх оноос 1,6%-иар өссөн үзүүлэлттэй байна. | |
| | 3 | Соёл, урлагийн салбарын ажилтнуудын амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | | Дэмжлэгт хамрагдсан ажилтны тоо | 0 | 1 | Дундговь аймаг 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах үүднээс Цагаандэлгэр сумын Соёлын төвийн 1 албан хаагчтай гэрээ байгуулан байрны түрээсийн төлбөр 150.000 төгрөг, гэр бүлд гачигдал гарсан 2 албан хаагчид 250,000 төгрөг, Хулд сумын соёлын төвийн 1 албан хаагчид урт хугацааны эмчилгээнд дэмжлэг үзүүлэн 709,760 төгрөг, Цагаандэлгэр сумын Соёлын төв 5 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт 1,200,000 төгрөгийн дэмжлэгийг 7 албан хаагчдад тус тус үзүүлж ажилласан байна.<br>Орон сууцанд орох хүсэлттэй салбарын албан хаагчдын судалгааг гаргасан. Энэхүү судалгааг үндэслэн ТХДЖТ-ын уран бүтээлч М.Эрдэнэбаяр, Э.Уранжаргал нартай аймгийн Засаг даргын Тамгын газраас 1 жилийн гэрээ байгуулан, хөнгөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулсан. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 4* Соёлын өвийг хамгаалах** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Бүртгэн баримтжуулж, хамгаалалтад авсан соёлын биет өв 269 байгааг 285-аар нэмэгдүүлнэ. | | Хамгаалалтад авсан соёлын биет өвийн тоо | 269 | 388 | Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 6 дэсийн 6 ширхэг үзмэрийг дагалдах 4 ширхэг хэрэгсэл, Мечта-75-ийн плетик, орос оёдлын машин, бөмбөр зэрэг эд хэрэгсэл тус музейд хэрэглэгдэж байсан анхны тоног төхөөрөмж болох 5 дэсийн 5 ширхэг үзмэр, Сайнцагаан сумын иргэн Г.Оюунтунгалагийн гар аргаар хатгаж урласан орны аравч зэрэг 19 дэсийн 19 үзмэр, Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Ганбатын эдэлж хэрэглэж байсан эд зүйлс болох 6 дэсийн 21 ширхэг үзмэр, Монгол улсын Ардын жүжигчин Нямын Дагийранз агсны шагналын одон медаль, тэмдэг, зарим эд зүйл болох 3 дэсийн 22 ширхэг үзмэр, Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Зууны манлай эмэгтэй уртын дуучин Н.Норовбанзад, Ардын жүжигчин Н.Дагийранз нарын хөрөг 2 уран зургийн бүтээлийг сан музейн сан хөмрөгт хүлээн авч бүртгэсэн. Нийт 39 дэсийн 79 ширхэг эд зүйлс үзмэрээр сан хөмрөгөө баяжууллаа. Дундговь аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоор улс, аймгийн хамгаалалтад байгаа 43 дурсгалт газрыг тоолж, шинээр 35 дурсгалт газрын 132 дурсгалыг илрүүлсэн. Мөн Сайнцагаан, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын иргэдийн гар дээр байгаа болон сүм хийдэд хадгалагдаж байгаа 250 баримтат өвийг бүртгэлд хамрууллаа. Нийт 461 соёлын биет өвийг бүртгэн хамгаалалтад авсан. | |
| Арга хэмжээ | 1 | Аймгийн түүх, соёлын өв, байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах Виртуал орчинг бүрдүүлэх | | Виртуал орчинг бүрдүүлсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | “Юникүе Повер Теч” ХХК-тай “Виртуал өв соёл” төслийг хэрэгжүүлэн, нэг жилийн хугацаатайгаар цахим сошиалаар сурталчилж ажиллахаар гэрээ хийж, Мандалговь хотын төв, Цагаан суварга, Их, Бага газрын чулуу, Дэлгэрийн хийд, Хайлаастын амны үзэсгэлэнт газрууд болон музейтэй цахимаар танилцах боломжийг бүрдүүлэн мэдээллийг цахимд байршуулж, 8669 иргэнд сурталчилж, үйлчилгээ үзүүллээ. С.Буяннэмэхийн 120 жилийн ойн хүрээнд үзүүллэг дэглэн, цахимаар олон нийтэд сурталчилж, түүх соёлоос танилцууллаа. Музейн танхимуудын цахим дэлгэц болон https://www.vrnomadic.mn/vrtours/vr-museum-dundgobi-museum/ цахим хаягаар өв соёлын дурсгалыг тогтмол сурталчиллаа. | 100 |
| | 2 | "Дуу хуурын өлгий" нутгийн онцлог өв соёлыг ирээдүй хойч | | Зохион байгуулах | 25 | 25 | ”Дуу хуурын өлгий” нутгийн залгамж халааг бэлтгэх ажлыг удирдан чиглүүлж, аймгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үедээ өвлүүлэн, залгамж халааг бэлтгэх | | дугуйлангийн төрлийн тоо | | | хэмжээнд соёл урлагийн байгууллагуудад уртын дуу, ардын богино дуу, эстрад дуу, хормогчин театр, хуруун хүүхэлдэй, хүүхэлдэйн жүжиг, хөтлөгч, тууль, исгэрээ, хөөмий, монгол уран зураг, сонгодог уран зураг, уран нугаралт, цагариг, жонглёр, дээс, алиалагч, илбэчин, морин хуур, хуучир, ёочин, ятга, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим, цахилгаан гитар, бөмбөр, шатар, даам, оюуны тоглоомын, уран уншлагын нийт 30 төрлийн дугуйланг хичээллүүлж байна. Зарцуулсан төсөв 6.393.420 төгрөг зарцуулсан. | |
| | | | | Дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо | 393 | 420 | ТХДЖТ, ТТХТ-ын дэргэд ардын бүжгийн дугуйланд 68, уртын дуу–57, ардын богино дуу-48, эстрад дуу-15, хормогчин театр 15, хуруун хүүхэлдэй 17, хүүхэлдэйн жүжиг 9, хөтлөгчийн сургалт 4, тууль, исгэрээ-32, хөөмий 6, зураг-31, цирк-16, морин хуур-28, ятга 8, ёочин 6, хуучир 2, төгөлдөр хуур 6, бөмбөр 23, цахилгаан хөгжим 13, уран уншлага-24, нийт 428 хүүхэд, соёлын төвүүдийн дэргэд ардын богино дуу, уртын дуу, морин хуур, ардын бүжиг, ардын хөгжим, шатар, даам, оюуны тоглоомын, уран уншлагын 9 төрлийн дугуйланд 526, нийт аймгийн хэмжээнд 30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрлийн дугуйланд давхардсан тоогоор 954 хүүхдийг хамруулж сургалаа. | |
| | 3 | Аймгийн түүхэн онцлог ёс заншил, зан үйл, өв уламжлал, түүх, соёлын дурсгалуудыг шингээсэн баримтат өвийг бий болгох | | Баримтат уран сайхны кино хийсэн эсэх Тийм-1 үгүй-0 | 0 | 1 | Аймгийн баримтат кино бүтээх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдон, киноны зохиолч, найруулагч, ажлын хэсгийн дарга гишүүдтэй хамтран ажиллалаа. Шаардагдах төлөвлөгөө, судалгааг цаг тухай бүрт боловсруулан гаргаж, мэдээллээр хангаж, үйл ажиллагааны талаар цахим болон цаасан архив үүсгэлээ. Киноны зохиолыг аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүд, ажлыг хэсгийн гишүүдэд танилцуулан, саналыг 3 удаа авч нэгтгэн зохиолчид хүргэлээ. Кино зохиолч Т.Нансалмаад ажлын хөлс 7 сая төгрөгийг гэрээ байгуулсны үндсэн дээр олгож ажиллалаа. Найруулагч Ононбатад холбогдох албан бичгийг боловсруулан хүргэлээ. Намрын зураг авалт Адаацаг, Дэлгэрцогт сумын нутагт адууны өв соёлтой холбоотой хийгдлээ. | 0 |
| Зорилт | 2 | 2020 онд аймгийн нийт өрхийн 38.1 хувь нь угийн бичиг хөтөлж байгааг 2024 онд 24 хувиар нэмэгдүүлнэ. | | Угийн бичгээ хөтөлсөн өрхийн эзлэх хувь | 38.1 | 50.1 | Соёл, урлагийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд угийн бичиг хөтлөхтэй холбоотой аяныг 14 суманд өрнүүлж, 37 удаагийн сургалтад 9261 иргэнийг хамруулж, 1856 ширхэг зөвлөмж, | 22,5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гарын авлага тарааж ажилласан. Үүний үр дүнд 437 өрх шинээр угийн бичгээ хөтөлж эхэлсэн. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 6053 өрх угийн бичиг хөтөлсөн нь нийт өрхийн 40,8 хувь нь болж байна. | |
| Арга хэмжээ | 1 | Иргэдийн угийн бичиг хөтлөх мэдлэг, чадварыг дээшлүүлэх | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо | 8149 | 10149 | Иргэдэд угийн бичиг хөтлөх арга зүйн 27 удаагийн сургалтыг явуулж 9261 иргэн хамруулан 26 удаагийн зөвлөгөө, 452 ширхэг гарын авлага тарааж ажилласан. | 55,6 |
| | 2 | Угийн бичиг хөтлөх ажлын үр дүнг үнэлж, дүгнэх | | Дүгнэх үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Соёл, урлагийн салбарын 18 байгууллагын 72 ажилтныг хамруулан угийн бичгийн болзлын төслийг танилцуулж хэлэлцүүлэг хийлээ. Хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган “Угийн бичигтэн өрх” шалгаруулах болзлыг боловсруулан, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/440 дүгээр захирамжаар батлуулж, бүх сумдад хүргүүлснээр анхан шатны шалгаруулалтыг сум орон нутагтаа хийж, тус болзлыг хангасан 6 сумын 16 өрхийн угийн бичгийг хүлээн авч дээрх болзлын дагуу дүгнэлээ. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 5* Хүн амд боловсролын үйлчилгээ үзүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Сургалтын чанарын үнэлгээний дунджийг 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 49 хувьд хүргэнэ. | | Боловсролын чанарын үнэлгээ Хувь | 39.1 | 45 | Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2022 оны байдлаар 39,5 хувьтай байна. | 6.7 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх | | СӨБ-ын хамран сургалтын хувь | 72.5 | 74 | 2022-2023 оны хичээлийн жилийн 2-4 настай хүүхдийн хамран сургалт 74,9 хувь байна. 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 84,6 байгаа нь өмнөх оныхоос 0,4 хувь өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| | 2 | Шаардлагатай суманд шинээр цэцэрлэгийн барилга барих | | Хөрөнгө нь шийдвэрлэгдсэн цэцэрлэгийн тоо | 2 | 3 | 2023 оны улсын төсөвт Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилга 2,470.4 сая, Дэлгэрцогт сумын 2 дугаар цэцэрлэгийн барилга 2,287.4 сая нийт 4,757.8 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвт тусгуулснаар шилжин хэрэгжиж байгаа 3 барилгаас 2 барилгын төсөв бүрэн суугдсан байна. | 100 |
| | 3 | Шаардлагатай сумдуудад хувилбарт сургалтыг зохион байгуулах | | Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо | - | 300 | Энэ хичээлийн жилд хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор хувилбарт сургалтыг 6 сумын 184 хүүхдийг хамруулан хамран сургалтын хувийг нэмэгдүүлсэн байна. | 30 |
| | | | | Шинээр нэмж ашиглалтад оруулсан гэр цэцэрлэгийн тоо | 5 | 1 | 2022 онд БШУЯ-аас явуулын багшийн үйлчилгээгээр хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлого барьж ажилласан. Гэр цэцэрлэг нэмэгдээгүй. | |
| | 4 | ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх | | Бага, суурь боловсролын хамран сургалтын хувь | 91.6 | 94.5 | 2021 оны жилийн эцсийн хүн амын тоотой харьцуулсан судалгаагаар Бага боловсролын хамран сургалт 94,3, суурь боловсролын хамран сургалт 96,1 байна. Аймгийн хэмжээний бага, суурь боловсролын хамран сургалтын дундаж хувь 95,1 хувь байна. emongolia системээс хаяг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харьяалал татдаг болсонтой холбоотой хамран сургалтын хувь өмнөх жилүүдээс 3,7 хувь өссөн байна. | |
| | 6 | Шаардлагатай сумдад шинээр сургуулийн барилга барих | | Шинээр ашиглалтад орсон сургуулийн тоо | 2 | 1 | Говийн-Ирээдүй цогцолбор сургуулийн барилгын гүйцэтгэл 45 хувьтай байна. Сайхан-Овоо сумын сургуулийн барилгын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй 2022 оны 12 сард ашиглалтад оруулж комисс хүлээж авлаа. Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн 640 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гэрээ байгуулагдаж, буулгалтын ажил хийгдсэн байна. | 100 |
| | 7 | Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим, байгалийн ухааны хичээлийн кабинетыг байгуулах | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхимын тоо | - | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхимыг Мандал, Говийн-Ирээдүй, Хулд, Өндөршил, Сайхан-Овоо, Дэрэн сумын сургуулийн байр болон дотуур байранд байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. | 100 |
| | | | | Байгалийн ухааны кабинетын тоо | 3 | 9 | Аймгийн ерөнхий боловсролын 9 сургууль хими, биологи, физик, багын байгалийн ухааны 11 кабинетыг шинээр байгуулж, байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг ахиулах материаллаг баазыг бүрдүүлэхэд 2022 онд 23,9 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. | |
| | 8 | Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай | | Гэрээ байгуулсан оюутны тоо | - | 8 | Аймгийн боловсролын салбарын 41 байгууллагаас 2022-2024 онд дутагдалтай байгаа багш нарын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх | | | | | судалгааг авч, нэгтгэн ЕБС-иудад 2022 онд 50, 2023 онд-17, 2024 онд 17 мэргэжлийн багшийн дутагдал үүсэх судалгаа гараад байна. Иймд орон нутагтаа хүний нөөцийн бодлогын хүрээнд МУБИС, МУИС-д суралцаж байгаа 1-4-р дамжааны нутгийн оюутнуудын судалгааг авч, МУБИС-ийн Оюутны албатай хамтран аймгийн харьяат 3-р дамжааны 9 оюутантай цахим уулзалт хийж, аймгийн 8 сургууль, цэцэрлэгийн удирдлагууд оролцон ажлын байрны саналыг хүргүүлэн ажиллаж, 2021-2022 оны хичээлийн жилд 3 оюутантай, 2022-2023 оны хичээлийн жилд 6 оюутантай гэрээ байгуулсан нь хүний нөөцийг бүрдүүлсэн арга хэмжээ болсон. Гэрээгээр төгсөж ирсэн оюутнууд Мандал, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумын сургуулиудад багшилж байна. | |
| | 9 | Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад улсад болон дотоодод урт хугацаанд мэргэжил дээшлүүлэх | | Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо | 4 | 8 | Сайнцагаан сумын ЭДЦС-ийн 2 багш Английн International House of London байгууллагын 2 сарын мэргэжил дээшлүүлэх цахим сургалт, Цэгцбилиг сургуулийн орос хэлний багш Санктпетер бургийн их сургуулийн ТРКИ сургалтад, аймгийн БШУГ-ын 1 мэргэжилтэн Солонгос улсад цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах сургалтад тус тус | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдаж гэрчилгээ авч, ажлын байрнаасаа гадаад орны туршлагаас суралцсан ажил болов. Гадаад хэлний 12 багшийг зуны амралтаар нь мэргэжил дээшлүүлэх вакум сургалтад хамруулсан. | |
| | 10 | 12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн баримжаа олгох сургалт, зөвлөгөө, сорилыг үе шаттай зохион байгуулах | | ЭЕШ-ын 10 хичээлийн дундаж оноо | 498,4 | 502 | БШУГ-ын Даргын баталсан хуваарийн дагуу 2 удаагийн сорилыг зохион байгуулж, 10 судлагдахууны сорилын даалгаврын гүйцэтгэлийг цахимаар танилцуулсан. Аймгийн Засаг даргын дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа Elab цахим сайтад БДБ олгож байгаа 8 сургуулийн 189 сурагчийн бүртгэлийг дахин сэргээн, тухайн сурагчдыг хариуцан ажиллах мэргэжлийн багш нарыг сайтад холбон ажиллуулсан. 2022 оны ЭЕШ-ын дундаж 509,59 оноотой шалгагдсан нь зорилтод түвшинд хүрсэн байна. | 100 |
| | 11 | Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 65 | Чадварлаг багш хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сургууль, цэцэрлэг бүр батлан, 2022 оны 11 сарын 1-ний байдлаар цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн дундаж 82, сургуулийнх 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 12 сургууль, цэцэрлэгийн 143 багш арга туршлагаа түгээн дэлгэрүүлж, 17 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судлагдахууны мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдан ажилласан багаараа багш нар хөгжиж, шинэ арга зүйг бий болгосон ажил болсон байна. | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 6*** **Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ. | | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 85.0 | 85.9 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн үйл ажиллагаанд зориулан 1,152,2 тэрбум төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 370,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, "Хүнну ресорус" ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 2,5 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч тус тус олгосон. Мөн Зооноз өвчин судлалын төвд 14,6 сая төгрөгийн EliZa уншигч, гүн хөлдөөгч, 500,0 мянган төгрөгийн автомакс зэрэг тоног төхөөрөмжүүдийг олголоо. Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд биохими, бүрэн болон хагас автомат анализатор, 3 партын гематологийн анализатор, EliZa уншигч, гүн хөлдөөгч, шүдний кресло/ком/, автоклав зэрэг 40 нэр төрлийн 644,7 сая төгрөгийн, Орон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 61,0 сая төгрөгийн, “Хүннү ресорус” ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олгоод байна. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90,6 хувьд хүрлээ. | |
| Арга хэмжээ | 1 | Сумдын эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах | | Хангагдсан сумдын тоо | 4 | 4 | Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгийн үнэ бүхий мобайл технологиор хангагдлаа. Ингэснээр 10 сум Мобайл технологиор хангагдаад байна. | 100 |
| | 2 | Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг оношилогоо, эмчилгээний дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах | | Тоног төхөөрөмжийн хангалт Хувь | 85.0 | 86.0 | Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд биохими, бүрэн болон хагас автомат анализатор, 3 партын гематологийн анализатор, EliZa уншигч, гүн хөлдөөгч, шүдний кресло/ком/, автоклав зэрэг 40 нэр төрлийн 644,7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 61,0 сая төгрөгийн, “Хүннү ресорус” ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олголоо. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 88,5 хувь боллоо. | 100 |
| | 3 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн автомашины | | Автомашины хангалт хувь | 90 | 93 | Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх ажлын | 66,6 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | парк шинэчлэлт, багийн эмч нарын унааг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглох | | | | | хүрээнд Дэлгэрхангай, Луус сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 92,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 157,6 сая төгрөгийн иж бүрэн тоноглогдсон автомашин, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Эрдэнэдалай, Хулд сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 66,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Probox суудлын автомашиныг шинээр тус тус олголоо. Автомашины хангалтын хувь 98,3 хувьд хүрлээ. | |
| | | | | Тоноглосон автомашины тоо | 1 | 2 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 157,6 сая төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн иж бүрэн тоноглогдсон эмнэлгийн автомашиныг олгож, Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг нийт 15,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тоноглолоо. | |
| | | | | Багийн эмчийн унааны Тоо | 1 | 8 | Хийгдээгүй. | |
| Зорилт | 2 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2020 онд 83.0 байсныг 2024 онд 85.0 хүргэнэ. | | Чанарын үзүүлэлтийн Хувь | 83.0 | 84.0 | Аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 төрлийн нийт 2,234,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгогдож эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна. Нийт 1015 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгнэхэд эерэг үзүүлэлт 0,1 хувиар өсөж, муу үзүүлэлт 0,1 хувиар буурсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу QR код уншуулан иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч байна. Хэрэглэгчийн үнэлгээний сайн үзүүлэлт 93,0 хувьтай байна. | |
| Арга хэмжээ | 1 | Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь | 29.7 | 31.8 | Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-тай хамтран Хулд, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад дотор, эмэгтэйчүүд, ЭХО, уушги харшил, зүрх судасны цахилгаан бичлэг, оношилгоог алслагдсан сумын 3344 иргэдэд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Нийт үзүүлсэн иргэдийн 62,0 хувь нь ковидын дараах хам шинж, 29 хувь нь амьсгалын замын үрэвсэл, 10,1 хувь нь тоосны харшил, 9,7 хувь нь арьсны харшил, 32,5 хувь нь даралт ихсэх, 20,0 хувь нь цээжний бах, 23,9 хувь нь бөөрний үрэвсэл, 21,9 хувь нь нойр булчирхайн үрэвсэл, 19,67 хувь нь ходоодны архаг үрэвсэл тус тус оношлогдсон байна. Бөөрний хавдар 3-ийг илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ. Аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн урьдчилан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 34,2 байна. | |
| | | | | Өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн хувь | 26.0 | 28.0 | Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая, Глобал сангийн 2,8 сая, нийт 22,8 сая төгрөгийн санхүүжилтээр 9 суманд “Сүрьеэгийн ирээдүйн төлөө хамтдаа” уриан дор сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын идэвхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, бэлгийн замаар дамжих халдвар болон ХДХВ/ДОХ-ын илрүүлэх шинжилгээ, сүрьеэ 1604 иргэнээс шинжилгээ авч тэмбүүгийн халдвар зэрэг 150 тохиолдол, баталгаажуулах шинжилгээгээр хуучин халдварын 136 тохиолдлыг тогтоож, шинэ 14 тохиолдлыг илрүүлэн 100 хувь эмчилгээнд хамруууллаа. Үзлэг оношилгоо эмчилгээнд нийт 6524 иргэд хамрагдсан бөгөөд өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн 30 хувьтай нарийн мэргэжлийн эмч нарын явуулын үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь 13,7, нийт давхардсан тоогоор 14 суманд үзлэг хийсэн. | |
| | 2 | Хот хоорондын зам дагуу болон алслагдсан сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах | | Цэг байгуулсан сумдын тоо | 1 | 1 | Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулснаар авто осол 29, бусдад зодуулсан 6, хугарал бэртэл 7, нохойд уруулсан 5, түлэгдэлт 6, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 5, угаартсан 1 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мориноос унасан 2 зэрэг нийт 62 хүнд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн. | |
| | 3 | Олон улсын эмнэл зүйн UP TO DATE ‘програмыг эмч бүр ашиглах,алсын зайн оношлогоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг комьпютер тоног төхөөрөмжөөр хангах | | Ашиглалтын хувь | 0 | 80 | Олон улсын эмнэлзүйн Up To Date программд байгууллагынхаа компьютероос чөлөөтэй бүртгүүлж хандах боломжийг бүрдүүлэх үүднээс эмнэлэг эрүүл мэндийн төвүүдээс интернэтийн гадаад хаяглалтын судалгааг авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүллээ. Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж сургалтад нийт 99 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа. UP TO DATE цахим платформыг нийт 110 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ашиглаж, нийт ашиглавал зохих эмч мэргэжилтнүүдийн 90,0 хувь нь ашиглаж байна | 100 |
| | | | | Хангалтын хувь | 45 | 80 | Эрүүл мэндийн газар, 15 сумын Эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 56,1 сая төгрөгийн үнэ бүхий суурин 24, зөөврийн 17, нийт 41 компьютероор хангагдсан. Эрүүл мэндийн газар алсын зайн сургалт мэдээллийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдаж, өрх сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй зайнаас холбогдох | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боломж бүрдсэн. Хангалтын хувь 100 | |
| | 4 | Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах | | Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлт/Просанти миль | 0 | 0 | Жирэмсний хяналтын чанарын сайжруулах ажлын хүрээнд аймгийн төвийн 2 өрх, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг "Ажлын байрны дадлагажуулах 10 хоног"-ийн сургалтад цахимаар 2, танхимын сургалт 1 удаа тус тус хамрууллаа. Жирэмсний хяналтад шинээр 575 жирэмсэн эх хамрагдсанаас жирэмсний эрт үеийн хяналт 93,2 хувьтай байна. Эхний 10 сарын байдлаар нийт 555 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 94,6 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрж, жирэмсэн төрөх, төрсний дараах үеийн хүндрэл бүртгэгдээгүй.<br>Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. | 100 |
| | | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт/Промиль | 10.0 | 9.5 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 7,2 промиль байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,2 промилиор буурсан үзүүлэлттэй байна. | |
| Зорилт | 3 | Халдварт бус өвчлөлийн түвшинг 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна. | | 10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин Промиль | 7441.5 | 7341.5 | 10000 хүн амд халдварт бус өвчний түвшин 7281,5 промиль байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчинг бүрдүүлэх. | | Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо | 37 | 43 | Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу 2022 онд “Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрчүүдээ хайрлая”, “Давсны хэрэглээгээ багасгая”, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус”, “Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя” зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 36670 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 25 удаа сургалт зохион байгууллаа. Иргэдэд эрүүл амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Илүүдэл жингүй Эртэч Монгол” 3 сарын аян, “Зөвийг хэвшүүлье” 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн 37679 иргэнийг хамруулан, мэдээлэл сургалт сурталчилгааг нийт хүн амын 82.3 хувьд хүргэлээ. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийн дагуу 2 материал ирүүлж, үнэлгээ хийж шалгаруууллаа. Ингэснээр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 38 болж нэмэгдэв. | 58,3 |
| | | | | Хог хаягдлын автоклаваар хангагдсан ЭМБ-ын тоо | 0 | 5 | Халдвар хамгаалал эрүүл ахуйн шаардлага хангах зорилгоор эрүүл мэндийн төвүүдэд нийт 15 автоклаваар хангагдсан бөгөөд аймгийн Нэгдсэн эмнэлэгт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зориулалтын автоклав байхгүй байна. Автоклавын хангалт 93,7 хувьтай байна. | |
| | 2 | Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх . | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь | 29.7 | 33.6 | “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо”-нд 0-17 насны 16752 хүүхэд хамруулахаас 90-ээс доошгүй хувийг, насанд хүрэгчдийн 4 насны багцын үзлэгт хамрагдвал зохих нийт 30790 хүнээс 30-аас доошгүй хувийг хамруулахаар төлөвлөж урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 34,2 хувьтай байна. | 93,7 |
| | | | | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь | 57.8 | 62.6 | 2022 оны байдлаар зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12078 иргэнээс 7839 буюу (64,9%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12974 иргэн хамрагдахаас 7810 буюу (60,2%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2568 иргэн хамрагдахаас 1610 буюу (62,6%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8449 иргэн хамрагдахаас 4993 буюу (59,1%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 61.7%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гипертензитэй 68, чихрийн шижинтэй 9 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авлаа. | |
| | | | | Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь | 59.4 | 69.4 | Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу 2022 онд “Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрчүүдээ хайрлая”, “Давсны хэрэглээгээ багасгая”, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус”, “Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя” зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 36670 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 25 удаа сургалт зохион байгууллаа. Иргэдэд эрүүл амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Илүүдэл жингүй Эртэч Монгол” 3 сарын аян, “Зөвийг хэвшүүлье” 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн 37679 иргэнийг хамруулан, мэдээлэл сургалт сурталчилгааг нийт хүн амын 82.3 хувьд хүргэлээ. | |
| | 3 | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан | | Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалтын хувь | 50.0 | 55.8 | Коронавируст халдварт өвчний үед эм, эмнэлгийн хэрэгслийн 18 нэр төрлийн 10 хоногийн нөөцтэй байна. Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалт 85,4, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 86,7 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх. | | Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 78.0 | 82.9 | Аймгийн хэмжээнд гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалт 90,3 хувьтай байна. | |
| | | | | Дархлаажуулалтын хамралтын хувь | 94.4 | 95.5 | Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс товлолын болон нэмэлт дархлаажуулалтад шаардлагатай вакцин, биобэлдмэл, тариур дагалдах хэрэгслийг улирал тутамд татан авч аймгийн хэмжээний нөөцийг бүрдүүлэн тасалдал үүсгэлгүй ажиллалаа. Товлолын дархлаажуулалтын үйл ажиллагааг Нэгдсэн эмнэлэг 1, сумын эрүүл мэндийн төвийн 15 дархлаажуулалтын цэгээр тус тус зохион байгуулж байсан ба энэ жил өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шинээр дархлаажуулалтын 2 цэгийг нээж, аймгийн хэмжээнд дархлаажуулалтын 18 цэгтэй боллоо. 2022 оны байдлаар заавал хийх товлолын дархлаажуулалтын хамралт 95,6 хувь байна. | |
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 10*** **Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ** | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1***. Газар тариалангийн бодлого зохицуулалт: газар тариалангийн тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээний 30 хувийг хангана. | УТ-15,5<br>ОНТ-10<br>8,0 | Хангамжийн хувь | 17,7 | 23 | Аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт төмс , хүнсний ногооны хэрэгцээний 20,2 хувийг хангаж байна. | 47,1 |

<table>
<tr><td rowspan="4">Арга хэмжээ</td><td rowspan="2">1</td><td rowspan="2">Төмс тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх</td><td rowspan="4">Хувийн хэвшил-35,8</td><td>Тариалсан талбайн хэмжээ га</td><td>27</td><td>30</td><td>Хаврын тариалалтыг төмс 29.4 га-д тариалаад байна.</td><td rowspan="2">69,8</td></tr>
<tr><td>Хураан авсан ургацын хэмжээ тн</td><td>238</td><td>274</td><td>Төмс 29.4 га-аас 239 тн-ийг хураан авсан байна.</td></tr>
<tr><td rowspan="2">2</td><td rowspan="2">Хүнсний ногоо тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх</td><td>Тариалсан талбайн хэмжээ га</td><td>16,2</td><td>18,2</td><td>Хаврын тариалалтыг 21.5 га-д хийж ургац хураалтын ажлыг зохион байгуулсан.</td><td rowspan="2">100</td></tr>
<tr><td>Хураан авсан ургацын хэмжээ тн</td><td>131</td><td>145,4</td><td>Хүнсний ногоо 21,5 га-аас 176,2 тн-ийг хураан авсан байна.</td></tr>
<tr><td colspan="9">Үндсэн чиг үүргийн нэр: 2. Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалт: Хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэнийн болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах</td></tr>
<tr><td rowspan="2">Зорилт</td><td rowspan="2">1</td><td rowspan="2">Мах сүүн сүүн бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 325,1 тн байсныг 2024 онд 482,2 тн-р нэмэгдүүлж хангамжийн хувийг 36,9 хувьд хүргэнэ.</td><td></td><td>Үйлдвэрлэлийн хэмжээ тн</td><td>325,1</td><td>392,5</td><td>Орон нутгийн үйлдвэрлэлээр нийт 4 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хүн амын хэрэгцээт талх нарийн боов-215,6 тонн мах, махан бүтээгдэхүүн -359,8 тонн сүү,сүүн бүтээгдэхүүн -7,4 мян.л-ийг үйлдвэрлэж өндөг 47,2 тонныг үйлдвэрлэж нийт 622,6 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.</td><td rowspan="2">100</td></tr>
<tr><td></td><td>Хангамжийн хувь</td><td>19,6</td><td>23,9</td><td>Хүн амын хэрэгцээт талх нарийн боов- 215,6 тонныг үйлдвэрлэж -8,5 хувийг, мах, махан бүтээгдэхүүн -359,8 тонныг үйлдвэрлэж -21,3 хувийг сүү,сүүн бүтээгдэхүүн -7,4 мян.л-ийг үйлдвэрлэж 0,2 хувийг, өндөг 47,2 тонныг үйлдвэрлэж 16,8 хувийг тус тус хангасан байна. Нийт 46,7 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан.</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Үйлдвэр цехэд бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээнд нийлүүлэх | - | Бэлтгэсэн махны хэмжээ Тн | 321,4 | 388,0 | Сайнцагаан суманд үйл ажиллагаа эрхэлдэг “ЭЭТМО” ХХК, “Их Хайрхан Мандал” ХХК-ны мал төхөөрөх цехэд 341,8 тн мах, мөн тус сумын бууз баншны үйлдвэрлэл эрхэлдэг 4 иргэн 18 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт 359,8 тн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. | 58 |
| | 2 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх | - | Нийлүүлсэн сүүний хэмжээ Мян.л | 3,7 | 4,5 | Мандалговь Хүнс ХХК-ны “Сүүн бүтээгдэхүүний” цех нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Тус цех нь энэ онд сүүн бүтээгдэхүүнийг шингэн сүүнд шилжүүлснээр 7,4 мян,л сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж ингэний хоормог 0,28 тн, хорхой ааруул 0,72 тн-ыг тус тус үйлдвэрлэж эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн сав баглаа боодолтой хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна. | 100 |
| **Үндсэн чиг үүргийн нэр: 3 Хөнгөн, *Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны* хөгжлийн бодлого, зохицуулалт**: Хөнгөн үйлдвэр, Жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ, хоршооны салбарт кластерын сүлжээг хөгжүүлэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2019 онд 17,5 хувь байсныг 2024 онд 23.3 хувьд хүргэнэ. | | ДНБ-д эзлэх хувийн өсөлт хувь | 17.5 | 20.3 | Аймгийн дотоод нийт бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 14.3 хувьтай байна. | 0 |
| | 1 | Арьс ширний анхан шатны тордолтын цех байгуулах | | Цехийн тоо | 1 | 2 | Арьс нэхий элдэх, эсгий боловсруулахаар төслөө ирүүлсэн Өлзийт, Сайнцагаан сумдын Баян булаг өрнөх, Талын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | | | | | | | цагаан эсгий хоршоодод ХХС-аас 70,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, Гурвансайхан сумын Голын цагаан овоо хоршоо шинээр байгуулагдаж арьс шир боловсруулах анхан шатны үйлдвэрлэл эрхэлж 12 ажлын байр бий болгоод байна. | |
| | | | | Ажлын байрны тоо | 3 | 6 | Шинээр 12 ажлын байрыг бий болгоод байна. | |
| | 2 | Өлзийт суманд ингэний фермерийн аж ахуйг байгуулж, сүүг үйлдвэр цехэд нийлүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлэх | | Саалинд хамрагдах ингэний тоо | 0 | 90 | Өлзийт сумын 4 малчин өрхөд 1 ээлжийн 50 ингийг түрээсийн гэрээгээр маллуулж байна. | 77.7 |
| | | | | Тухайн жилд нийлүүлсэн сүүний хэмжээ тн | 0 | 4 | 5,5 тонн сүүг зах зээл нийлүүлээд байна. | |
| | 3 | Сумдад мал төхөөрөх цех байгуулах | ТХ 150.0 | Цехийн тоо | 5 | 8 | Өндөршил сумын Азтай маамнууд ХХК “Мал төхөөрч мах ангилах” 170 м2 талбай бүхий үйлдвэрийн байрыг барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс Сайнцагаан сумын Баянзэгстийн говь, Сайхан-Овоо сумын ИХ бадрах хайрхан ХХК-иудад мал төхөөрөх, малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах 2 төсөлд 150,0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж | 75 |
| | 4 | Орон нутгийн онцлогтой хоршоодыг байгуулах | | Шинээр бий болсон хоршоо | - | 3 | 2022 онд Ажирхайн оргил, Их бадрах хайрхан, Онги нутгийн буян, Загийн алим эко, Голын цагаан овоо, Гурван-Өндрийн шим хоршоод шинээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулагдсанаар аймгийн хэмжээнд нийт 9 хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна. | |
| | 5 | Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах цэгийг шинээр байгуулан борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх | ОНТ 50.5 | Цэг байгуулагдсан эсэх Тийм – 1, Үгүй - 0 | 0 | 1 | Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, зах зээлд зуучлах “Дундговьд үйлдвэрлэв” төв Орон нутгийн төсвийн болон ЗЗББУТ-ийн 419,0 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орлоо. 2022 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 50,5 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж авч тохижуулсан. | 100 |
| | | | | Тухайн жилийн борлуулалтын орлого Сая.төг | 164 | 220 | Уг борлуулалтын төвтэй болсноор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломж бүрдэж өнөөгийн байдлаар 287,0 сая төгрөгийн борлуулалт хийжээ | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:4 Мал аж ахуйн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах***: Мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль цаг агаарын эрсдлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, бүртгэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд нэвтрүүлнэ. | | Хамрагдсан хонины тоо | 0 | 800 | Битүү хөнгөлгөөний аргыг 500 хурга, 150 ишиг, 30 бяруунд туршиж нийт 1030 малд биотехнологийн ололтыг нэвтрүүллээ. 8 сартай хурганы амьдын жинг 7-12кг, махны гарцыг 3-5кг нэмэгдүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх | | Бойжуулсан төлийн тоо | 0 | 500 | Сайнцагаан омгийн хээлтэгчид Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр энэ онд 350 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Нийт 1150 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна. | 100 |
| | 2 | Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг эзэмгжүүлэн бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах | | Тухайн жилд эзэмгжүүлж бүртгэлжүүлсэн малын Тоо | 21000 | 25000 | Мал эзэмгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд сумдад стандартын шаардлага хангасан 6200 толгой бог малын хээлтэгч, хээлтүүлэгч, хэрэгцээний сүргийг эзэмгжүүлэн бүртгэлжүүллээ. Аймгийн хэмжэээнд нийт 96,2 мян.толгой малыг эзэмгжүүлж бүртгэлжүүлээд байна. | 100 |
| Зорилт | 2 | Талхлагдсан 110,0 мянган га бэлчээрийн талбайг сэргээж, усан хангамжийг 0.7 хувиар нэмэгдүүлнэ. | | Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ Мян.га | 100,0 | 20, 0 | Өвөлжөө, хаваржааны дэргэд 43,3 га бэлчээр хашиж, 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалан 29,6 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэн нийт 29,6 мянган га бэлчээрийн талбайг нөхөн сэргээгээд байна. | 100 |
| | | | | Усан хангамж нэмэгдүүлсэн хувь | 50,3 | 50,8 | 110,0 мянган га талбайг шинээр усжуулж бэлчээр усжуулалтыг 1,5 хувиар нэмэгдүүлж усан хангамж аймгийн хэмжээнд 51,8 хувь боллоо. | |
| Арга хэмжээ | 1 | Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх | | Тухайн жилд тэмцсэн талбайн хэмжээ Мян.га | 100,0 | 20,0 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 185 дугаар тогтоол “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Үлийн цагаан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оготнотой тэмцэх" А/166 захирамжаар Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар 29,5 мянган га талбайд тэмцсэн. | |
| | 2 | Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах | | Тухайн жилд шинээр гаргасан худгийн тоо | 23 | 10 | Төсөл хөтөлбөр, Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 810,6 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдуудад инженерийн хийцтэй 25 худаг, Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдуудад 27 цооног гаргаж ашиглалтад оруулсан. | 100 |
| | 3 | Тэжээлийн олон наст ургамал тариалах | | Тухайн жилд бэлчээрийн олон наст тариалсан талбайн хэмжээ га | 0 | 3 | Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо,Хулд, Эрдэнэдалай сумдын 17 малчин өрх 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалсан. | 100 |
| Зорилт | 3 | Айргийг аймгийн брэнд бүтээгдэхүүн болгон баталгаажуулах | | Баталгаажуулсан эсэх Тийм-1, үгүй-0 | 0 | - | ХААИС, МААХ-ийн хамтарсан мэргэжлийн баг айргийг орон нутагт ажиллаж арга зүйгээ батлуулсан ч Лабораторийн судалгааны ажил түр хойшлогдоод байна | 0 |
| Арга хэмжээ | 1 | Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах | | Хамтран ажилласан байгууллагын тоо | 0 | 1 | Айргийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан хөгжүүлэх зорилгоор ХААИС-тай хамтарч арга зүйгээ батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Лабораторын судалгааны ажил хийгдэх | | Лаборторын судалгаа хийгдсэн тоо | 0 | 3 | Айрагны лабораторын судалгааны ажил хийгдэх бэлэн болсон хэдий ч төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу шаардагдах төсөв хойшлогдсон. | 0 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:5 Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх:*** Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, суурь баазыг бэхжүүлэх, шинэчлэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Нийт мал сүргийн 20-с доошгүй хувийг дархлаажуулна. | | Тухайн онд дархлаажуулсан малын эзлэх хувь | 16,2 | 23.8 | 2082673 мал сүргийн дархлаажуулалтад хамруулсанаар нийт мал сүргийн 67,3 хувийг эзэлж байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Тархвар зүйн судалгаанд үндэслэн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулах | | Хамруулсан малын тоо Мян.тол | 650.0 | 740.0 | Мал амьтны халдварт Галзуу, Дуут хавдар, Дотрын халдварт хордлого,Шөвөг яр, Сахуу зэрэг 5 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 726852 толгой мал хамруулсан. | 84.4 |
| | 2 | Малын халдварт, цусны шимэгч, зооноз, эндемик өвчний судалгааг аймгийн мал эмнэлгийн лабораторид хийх | | Тухайн жилд судалгаанд хамрагдсан сорьц Тоо /мянга/ | 13.0 | 17.0 | Мал эмнэлгийн лаборатори нь 2022 оны байдлаар Нян, ийлдэс, молекул биологи, шимэгч судлал, ариун цэврийн лабораторит нийт 256 хандалтаар **17220** сорьцод шинжилгээ хийж хариуг гаргасан байна. | 100 |
| | 3 | Сум бүрийг вакцин хадгалах хөргүүртэй болгох | | Тухайн жилд хөргүүртэй болсон сумын тоо | 0 | 5 | Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Эрдэнэдалай 6 сум Тэнүүн хишиг ХХК -аас вакцин хадгалах хөргүүр худалдан авч ашиглаж байна. | 100 |

**Нийт : Ерөнхий чиг үүрэг : 10, Үндсэн чиг** үүрэг **: 40, Зорилт: 52, Арга хэмжээ: 164**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХШҮХ-ИЙН ДАРГА Д.ДААРИЙМАА

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ПЭРЭНЛЭЙМАА